



Замын-Үүд сүм

1370110



1 дэх хэсэгт заасан асуудлыг шийдвэрлэх шүүгчийг Эрүүгийн хэргийн бүртгэл, хяналтын системд

1. Шүүгч Э.Болормаа гэсэн дарааллаар тойрог үүсгэх

в. Зөрчлийн хэргийг бүртгэл, хяналтын системд

1.Шүүгч Э.Болормаа гэсэн дарааллаар тойрог үүсгэх

г.Ээлжээр ажиллах шүүгчийг бүртгэл хяналтын системд

1.Шүүгч Э.Болормаа

д.Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны “Иргэн-2014” нэгдсэн системд

1. Шүүгч Э.Болормаа гэсэн дарааллаар тойрог үүсгэх

1.3. Шүүгчдийн зөвлөгөөний тогтоолоор тогтоосон дарааллаар шүүгчдийн нэрс, хэрэг хуваарилалтыг Эрүүгийн хэргийн бүртгэл, хяналтын нэгдсэн систем, Иргэн-2014 нэгдсэн систем, “Цахим шүүх 2.0” системд Шүүхийн тамгын газрын дарга, Ерөнхий шүүгчийн туслах нарын хяналт дор тэмдэглэл үйлдэн, дүрс бичлэгээр баталгаажуулан мэдээлэл технологийн мэргэжилтнээр тохиргоо хийлгэхийг шүүхийн тамгын газрын даргад даалгасугай.

2. Хэрэг хянан шийдвэрлэх хуралдаан даргалагч болон шүүх бүрэлдэхүүнийг томилох.

/Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 19.2.2/

2.1. Шүүгч хүлээн авсан хэрэг, маргаанаа өөрөө даргалж шийдвэрлэх бөгөөд Эрүүгийн хэргийн хувьд шүүх бүрэлдэхүүнийг урьдчилан мэдэх боломжгүй, санамсаргүй тохиолдлоор программ ашиглан сонгож, Ерөнхий шүүгч бүрэлдэхүүнд орсон тохиолдолд хуралдааныг даргалах, Иргэний хэргийн хувьд илтгэгч шүүгч өөрөө хуралдааныг даргалж, үлдэх хоёр шүүгч шүүх бүрэлдэхүүнд орохоор сонгосугай.

2.2. Шүүх бүрэлдэхүүнд томилогдсон шүүгч өвчтэй, чөлөөтэй, ээлжийн амралттай зэрэг шалтгаанаар тухайн шүүх хуралдаанд оролцох боломжгүй байдал үүссэн тохиолдолд адил шатны өөр шүүхээс томилогдсон шүүгчийг албажуулсугай.

2.3. Шүүх тодорхой хэргийг хянан хэлэлцэх бүрэлдэхүүнгүй болсон бол Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 3.3 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт зааснаар “Сум буюу сум дундын, дүүргийн шүүх, түүнчлэн аймаг, нийслэлийн шүүх тодорхой эрүүгийн хэргийг хянан хэлэлцэх бүрэлдэхүүн хүрэлцэхгүй болсон бол сум буюу сум дундын, дүүргийн шүүхийн бүрэлдэхүүнд орох шүүгчийг харьяалах аймаг, нийслэлийн шүүхийн Ерөнхий шүүгчийн, аймаг, нийслэлийн шүүхийн бүрэлдэхүүнд орох шүүгчийг Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын Тэргүүний шийдвэрээр шүүгчдийн зөвлөгөөнөөс тогтоосон журмыг баримтлан томилно.” гэсний дагуу шийдвэрлэсүгэй.

2.4. Иргэний шүүх хуралдаанд бүрэлдэхүүн хүрэлцэхгүй тохиолдолд адил шатны шүүхийн Ерөнхий шүүгчтэй зөвшилцөн бүрэлдэхүүн томилохдоо ИХШХШТ-ийн 78 дугаар зүйлийн 78.6-д заасан “Тодорхой хэргийг хянан хэлэлцэх бүрэлдэхүүн хүрэлцэхгүй болсон тохиолдолд адил шатны өөр шүүхийн Ерөнхий шүүгчтэй



зөвшилцөж, тухайн шүүхийн Ерөнхий шүүгчийн захирамжаар өөр шүүхийн шүүгчийг томилж, оролцуулна” гэсэн хуулийн заалтын дагуу шийдвэрлэсүгэй.

2.5. ИХШХШТ-ийн 78 дугаар зүйлийн 78.6-д заасан тодорхой хэргийг хянан хэлэлцэх бүрэлдэхүүн хүрэлцэхгүй болсон тохиолдолд адил шатны өөр шүүхийн шүүх бүрэлдэхүүнд оролцох шүүгчийг томилсугай.

### 3.Хэрэг хуваарилах журам батлах /Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 19.2.5/

3.1. “Эрүүгийн болон зөрчлийн хэрэг, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах, шүүгчид хуваарилах журам”-ыг нэгдүгээр хавсралтаар, “Иргэний хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, хүсэлт хүлээн авах, шүүгчид хуваарилах журам”-ыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3.2. 2025 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 05 дугаартай шүүгчдийн зөвлөгөөний тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

### 4.Ерөнхий шүүгчийн албажуулах ажиллагаа

4.1. Шүүх хуралдааны даргалагч болон шүүх бүрэлдэхүүнийг томилсон шүүгчдийн зөвлөгөөний тогтоолоор тогтоосон дарааллын дагуу эрүү, зөрчлийн хэргийг Эрүүгийн хэргийн бүртгэл хяналтын нэгдсэн систем, “Цахим шүүх 2.0” цөм систем, Иргэний хэргийн “Иргэн-2014” нэгдсэн системээс хуваарилсныг Ерөнхий шүүгч Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3-т зааснаар захирамж гаргаж албажуулсугай.

4.2. Уг тогтоолын биелэлтийг Ерөнхий шүүгч зохион байгуулсугай.

### 5.Бусад

5.1. “Хүндэтгэн үзэх шалтгаан” гэдгийг сэлгэн ажиллах, ар гэрийн гачигдал гарах, 14 хоногоос дээш хугацаагаар сургалтад хамрагдах, гэнэт өвдөх, ээлжийн амралттай байх хугацаа зэргийг ойлгосугай.

5.2. “ээлжээр ажиллах шүүгч” гэж ажлын бус цагаар, долоо хоногийн амралтын өдөр, нийтээр амрах баярын өдөр сэжигтний баривчлах асуудлыг шийдвэрлүүлэхээр тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс тогтоосон хуваарийн дагуу томилогдсон шүүгчийг ойлгосугай.

5.2. Шүүгч нарын тоо нэмэгдэх, хасагдах болон хэрэг, нэхэмжлэл хуваарилах явцад энэ журмаар зохицуулаагүй асуудлууд гарвал тухай бүрд нь шүүгчдийн ээлжит бус зөвлөгөөнийг зарлан хуралдуулж шийдвэрлүүлсүгэй.

5.3. Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авах, хуваарилах, хэрэг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүн томилох үйлдэл бүрийг дүрс бичлэг хийж 7 хоног бүр хадгалах төхөөрөмжид хуулбарлан хадгалах ба түүнд тогтмол хяналт тавьж ажиллахыг тус шүүхийн тамгын газрын даргад даалгасугай.

5.4. Энэхүү журмыг Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.4 дэх хэсэгт зааснаар тус шүүхийн мэдээллийн самбар болон цахим хуудсанд олон нийтэд нээлттэй байршуулахыг Шүүхийн тамгын даргад даалгасугай.

ДАРГАЛАГЧ, ЕРӨНХИЙ ШҮҮГЧ



Э.БОЛОРМАА



Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь  
сум дундын шүүхийн Шүүгчдийн  
зөвлөгөөний 2026 оны 12 дугаар сарын  
22-ны өдрийн 01 дугаартай тогтоолын  
нэгдүгээр хавсралт

ЕОГ 0007 9075-46

Шүүхэд Эрүүгийн болон Зөрчлийн хэрэг, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах,  
шүүгчид хуваарилах журам

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Эрүүгийн болон Зөрчлийн хэрэг хуваарилах, таслан сэргийлэх арга хэмжээтэй холбогдох асуудлыг шийдвэрлэх, шүүхийн шийдвэрийг биелүүлэх ажиллагаа болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гарсан өргөдөл, гомдол, хүсэлтийг шийдвэрлэхэд энэхүү "Журам"-ыг баримтална.

1.2. Шүүх хэрэг болон сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлгүй баривчлах саналыг дараах байдлаар хүлээн авсугай.

а. 3 ба түүнээс дээш яллагдагчтай, 3 ба түүнээс дээш хавтастай, овор хэмжээ ихтэй эд мөрийн баримттай хэргийг тухайн өдрийн ажлын цаг дуусахаас хоёр цагийн өмнө хүлээн авах

б. Дээрхэд зааснаас бусад эрүүгийн хэрэг болон зөрчлийн хэргийг тухайн өдрийн ажлын цаг дуусахаас нэг цагийн өмнө хүлээн авах

в. Сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлгүй баривчлах саналыг хуанлийн өдөр бүр шөнийн цагаас бусад цагт тасралтгүй авна.

1.3. Шүүхийн тамгын газрын мэдээлэл лавлагааны мэргэжилтэн шүүхэд ирсэн хэрэг, өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авсан даруйд нэгдсэн системд оруулан тойрог дотор санамсаргүй хуваарилалт хийж, дардас даран, хүлээн авсан бүртгэлийн дэвтэрт цаг, минутын дарааллаар бүртгэн, хуваарилагдсан шүүгчид, хүндэтгэн үзэх шалтгаанаар шүүгчид хүлээлгэн өгөх боломжгүй бол шүүгчийн туслахад гарын үсэг зуруулж хүлээлгэн өгнө.

1.4. Шүүхийн тамгын газрын мэдээлэл лавлагааны мэргэжилтэн нэгдсэн системээр хуваарилагдсан хэрэг, өргөдөл, гомдол, хүсэлтийг хэзээ, хэрхэн хуваарилагдсан тухай баримтыг оролцогч этгээдийн хүсэлтээр хэвлэн өгч, өгсөн тохиолдолд энэ баримтыг хэрэгт хавсаргана.

1.5. Тус шүүхэд ирсэн эрүүгийн болон зөрчлийн хэрэг, өргөдөл, гомдол, хүсэлт, дүгнэлтийг системээс "тойрог дотор санамсаргүй сонгогдох зарчим"-аар хуваарилна.

1.6. Цаасан болон цахим баримт бичиг, албаны цахим шуудангаар хүлээн авсан, байгууллагын үндсэн үйл ажиллагаанд хамаарах, удирдлагын түвшинд шийдвэрлэх



баримт бичгийг төвлөрсөн бүртгэлд бүртгэж, холбогдох өгөгдлийг "Цахим шүүх 2.0" цөм системийн зохих программд оруулах ажлыг Тамгын газрын даргын тушаалаар томилогдсон эрх бүхий ажилтан хэрэгжүүлнэ.

#### Хоёр. Хэрэг хуваарилах арга

2.1. Шүүхэд ирсэн эрүүгийн хэрэг, өргөдөл, гомдол, хүсэлтийг Эрүүгийн хэргийн бүртгэл, хяналтын нэгдсэн системээс "тойрог дотор санамсаргүй сонгогдох зарчим"-аар доорх 4 аргаар хуваарилна.

а/ "Ердийн журмаар" б, в, г-д зааснаас бусад бүх хэргийг хуваарилна.

б/ "Ачаалал тэнцүүлж хэрэг хуваарилах арга"-аар 3-аас дээш хавтастай болон 5-аас дээш холбогдогчтой хэргийг,

в/ "Тодорхой төрлийн хэрэг хуваарилах арга"-аар Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.6 дүгээр зүйл, 17.1 дүгээр зүйл, 27.10 дугаар зүйл, 18.5 дугаар зүйлчлэлтэй хэргүүдийг хуваарилна.

г/ "Бусад" аргаар давж заалдах болон хяналтын шатны шүүхээс анхан шатны шүүхийн шийдвэр хүчингүй болж дахин шийдвэрлүүлэхээр буцаж ирсэн хэргийг тухайн шийдвэрлэсэн шүүгчид, мөрдөн байцаалтад буцаасан хэргийг буцаасан шүүгчид нь хуваарилна.

2.2. Тодорхой төрлийн хэрэг, өргөдөл, гомдол, хүсэлтийг дор дурдсанаар хуваарилна.

2.2.1. Давж заалдах болон хяналтын шатны шүүхэд гомдол гаргах хугацаа сэргээлгэх хүсэлтийг хэргийг шийдвэрлэсэн шүүгчид өгнө.

2.2.2. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд байгаа хэрэгт холбогдуулан гаргасан гомдол, хүсэлтийг тухайн хэргийг шийдвэрлэх шүүгчид өгнө.

2.2.3. Шүүхийн шийдвэрийг биелүүлэхтэй холбоотой Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 37.1-37.12 дугаар зүйлд заасны дагуу ирүүлсэн хүсэлтийг өмнө нь уг хэргийг шийдвэрлэсэн шүүгчид хүлээлгэн өгөх бөгөөд хэрэв тухайн шүүгч 3-аас дээш хоногоор эзгүй тохиолдолд дараагийн шүүгчид, адил шатны өөр шүүхийн шийдвэрийг биелүүлэхтэй холбоотой асуудлыг уг тогтоолын 1.1.а-д заасан дарааллаар хуваарилна.

2.2.4. Шийтгэх тогтоол нь 2 удаа хүчингүй болсон, цагаатгах тогтоолыг хүчингүй болгосон, шүүгчийг татгалзан гаргах тухай хүсэлтийг хүлээн авсан тохиолдолд тухайн



шүүгчид хуваарилахгүйгээр "Ердийн, ачаалал тэнцүүлэх, тодорхой төрлийн хэрэг хуваарилах" аргуудын аль нэгээр тойрог дотор санамсаргүй сонгогдох зарчмаар хуваарилах ба цагаатгах тогтоол хүчингүй болж дахин шийдвэрлүүлэхээр ирсэн хэргийг шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүн байхгүй тохиолдолд адил шатны өөр шүүх рүү хэргийг шийлжүүлэхээр шийдвэрлэнэ.

2.2.5. Харьяалал тогтоож ирүүлсэн, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хүчингүй болж ирсэн хэргийг "Ердийн, ачаалал тэнцүүлэх, тодорхой төрлийн хэрэг хуваарилах" аргуудын аль нэгээр тойрог дотор санамсаргүй сонгогдох зарчмаар хуваарилна.

2.2.6. ЭХХШТХ-ийн 12.3, 13.1, 13.2, 13.5, 13.7, 14.1 дүгээр зүйлийн 1.2, 1.3, 1.5, 14.4, 14.5, 14.13, 19.2, 19.3 дугаар зүйл, 21.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 21.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан асуудлыг шийдвэрлэх асуудлыг уг тогтоолын 1.2-ийн "Б" -д заасан тойргоор хуваарилна.

2.2.7. Зөрчлийн хэргийг "Цахим шүүх 2.0" цөм систем санамсаргүй байдлаар хуваарилна.

2.2.8. Ээлжээр ажиллах шүүгчид ЭХХШТХ-ийн 14.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.3, 1.5, 31.5 дугаар зүйлд заасан асуудлыг улирал тус бүрээр энэ тогтоолын 1.2-ийн "Г" -д заасан тойргоор хуваарилна.

#### Гурав. Бусад

3.1. Хуваарилагдсан хэрэг, өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авсан шүүгч, шүүх бүрэлдэхүүнд томилогдсон шүүгчийг гагцхүү хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмаар зөвшөөрөгдсөн татгалзал, үндэслэл үүссэн, эсхүл шүүгч, шүүх бүрэлдэхүүн солигдох бусад нөхцөлд тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс тогтоосон журмын дагуу шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг томилно. Зөвлөгөөний шийдвэрийг үндэслэн хэрэг, өргөдөл, гомдол, хүсэлтийг хуваарилахдаа тухайн шүүгчийг тойргоос гарган бусад шүүгч нарт тойрог дотор санамсаргүй байдлаар системээс хуваарилна.

3.2. Эрүүгийн хэрэг хуваарилагдсан шүүгч зайлшгүй хүндэтгэн үзэх шалтгаанаас бусад тохиолдол болон ЭХХШТХ-ийн 34.16 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт зааснаар шүүх хэргийг хянан хэлэлцэхийг 60 хүртэл хоногоор хойшлуулсан тохиолдол хэргийг шүүгч өөрөө шийдвэрлэж дуусгах, шүүгчид ээлжийн амралт эхлэхээс хуанлийн 14 хоногийн өмнө хэрэг хуваарилалтыг зогсоож, ажилд орохоос ажлын 5 хоногийн өмнө хэрэг хуваарилна.

3.3. Шүүгч ээлжийн амралтаа дутуу эдлээд 14 хоногоос дээш хугацаагаар нөхөж амрах тохиолдолд хэрэг хуваарилалтыг амрахын өмнөх өдрөөс эхлэн зогсоож, ажилдаа орох өдөр нь хэргийг хуваарилна.

3.4. Зөрчлийн хэрэг хуваарилагдсан шүүгч зайлшгүй хүндэтгэн үзэх шалтгаанаас бусад тохиолдолд хэргийг өөрөө шийдвэрлэж дуусгах, шүүгчид ээлжийн амралт



эхлэхээс ажлын 5 хоногийн өмнө хэрэг хуваарилалтыг зогсоож, ажилд орсон өдрөөс хэргийг хуваарилна.

3.5. Шүүгч хуанлийн 14 хоногоос дээш хугацаагаар өвчтэй, чөлөөтэй, сургалтанд хамрагдах тохиолдолд хэрэг хуваарилахгүй бөгөөд түүнд өмнө нь хуваарилагдсан хэргийг бусад шүүгч нарт хэрэг ирсэн огнооны дарааллаар хамгийн сүүлд хэрэг авсан шүүгчийн дараагийн шүүгчээс эхэлж, уг тогтоолын 1.1.а-д заасан нэрсийн дарааллын дагуу тойрог дотор санамсаргүй хуваарилна.

3.6. Шүүх хуралдаан хойшилсон нь шүүгч, шүүх бүрэлдэхүүн өөрчлөгдөх үндэслэл болохгүй. Шүүгч, шүүх бүрэлдэхүүнд томилогдсон шүүгч хүндэтгэн үзэх шалтгааны улмаас бүрэлдэхүүнд оролцох боломжгүй тохиолдол нь дээрх зохицуулалтад хамаарахгүй.

3.7. Ерөнхий шүүгчид хэргийг ердийн журмаар, ачаалал тэнцүүлж, тодорхой төрлийн хэрэг хуваарилах аргуудын аль нэгээр бусад шүүгчдийн нэгэн адил хуваарилахаас гадна хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хянан шийдвэрлэх, болон бусад өргөдөл, гомдол, хүсэлтийг нэгэн адил хуваарилна.

3.8. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 13.5 дугаар зүйлд заасан асуудлыг шийдвэрлэсэн шүүгчид хэргийг хуваарилахгүйгээр системээс алгасах чагт товчийг ашиглаж тайлбар хийж хэргийг "Ердийн, ачаалал тэнцүүлэх, тодорхой төрлийн хэрэг хуваарилах" аргуудын аль нэгээр тойрог дотор санамсаргүй сонгогдох зарчмаар хуваарилна.

3.9. Шүүгч эзгүй тохиолдолд Эрүүгийн хэргийн бүртгэл, хяналтын нэгдсэн системд байршуулсан нэрсийн дарааллаар бие, биенээ тойргийн байдлаар орлон ажиллах ба энэ дарааллыг баримтлах боломжгүй тохиолдолд ганцаараа үлдсэн хэн байгаа шүүгч нь бүгдийг орлон ажиллана.

3.10. Таслан сэргийлэх арга хэмжээг шийдвэрлэсэн шүүгчийн захирамжид гомдол гаргасан тохиолдолд Ерөнхий шүүгч өөрийн гаргасан захирамжийг өөрөө хянах боломжгүй тул адил шатны өөр шүүхийн Ерөнхий шүүгчид гомдлыг шийдвэрлүүлэхээр шилжүүлнэ.

3.11. Ерөнхий шүүгч, шүүгч тухайн шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой албан хэрэг хөтлөлтөд "Цахим шүүх 2.0" цөм систем, тоон гарын үсгийг ашиглана.



Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь  
сум дундын шүүхийн Шүүгчдийн  
зөвлөгөөний 2026 оны 12 дугаар сарын  
22-ны өдрийн 01 дугаартай тогтоолын  
хоёрдугаар хавсралт

Б 07 0007 9078 46

Шүүхэд Иргэний хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт,  
хэрэг хүлээн авах, шүүгчид хуваарилах журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Шүүхэд нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт, хэрэг хүлээн авах, шүүгчид хуваарилахдаа Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль /цаашид "ИХШХШТХ" гэх/ болон Иргэний хэргийн хөдөлгөөний нийтлэг аргачлалыг баримтлан Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны Иргэн-2014 нэгдсэн системээр хуваарилахдаа энэхүү журмыг баримтална.

1.2. Шүүхэд хүлээн авч байгаа нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт хэргийг шүүхийн мэдээлэл-лавлагааны мэргэжилтэн ажлын цагт ИХШХШТХуулийн 62 дугаар зүйлд заасны дагуу бүрдүүлбэрийг шалгаж ирсэн цаг, минутын дарааллаар хүлээн авч тэмдэглэлээ хийж "Нэхэмжлэл хүлээн авах бүртгэлд"-д бүртгэнэ.

1.3. Шүүхийн тамгын газрын мэдээлэл лавлагааны мэргэжилтэн шүүхэд ирсэн хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авсан даруйд нэгдсэн системд оруулан тойрог дотор санамсаргүй хуваарилалт хийж, дардас даран, хүлээн авсан бүртгэлийн дэвтэрт цаг, минутын дарааллаар бүртгэн, хуваарилагдсан шүүгчид, хүндэтгэн үзэх шалтгаанаар шүүгчид хүлээлгэн өгөх боломжгүй бол шүүгчийн туслахад гарын үсэг зуруулж хүлээлгэн өгнө.

Хоёр. Хэрэг хуваарилах арга

2.1. Шүүхэд ирсэн хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлтийг нэгдсэн системээс урьдчилан мэдэх боломжгүй, тойрог дотор санамсаргүй тохиолдлын аргаар хуваарилахдаа "Ердийн журмаар хуваарилах арга"-ыг ашиглана.

а. "Ердийн журмаар хуваарилах арга" нь бусад аргаар хуваарилах хэрэгт хамаарахгүй бүх төрлийн хэрэгт хамаарна.

2.2. Давж заалдах болон хяналтын шатны шүүхэд хэрэг хянагдаж шийдвэр нь хуулийг буруу хэрэглэсний улмаас хүчингүй болж дахин хэлэлцүүлэхээр ирүүлсэн хэргийг "тойрог дотор санамсаргүй" аргаар хуваарилна.



2.3 Адил шатны шүүхээс шилжиж ирсэн хэрэг, харьяалал тогтоож ирүүлсэн хэрэг, гомдол, хүсэлт зэргийг “тойрог дотор санамсаргүй” аргаар хуваарилна.

2.4 Давж заалдах болон хяналтын шатны шүүхэд хэрэг хянагдаж шийдвэр нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа зөрчсөн үндэслэлээр хүчингүй болж дахин хэлэлцүүлэхээр ирүүлсэн хэрэг, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шийдвэр хүчингүй болсон хэрэг, ИХШХШТХ-ийн 74, дүгээр зүйлд зааснаар хэрэг хянан шийдвэрлэсэн шүүгчийн захирамжийг тус хуулийн 124 дүгээр зүйлд зааснаар хүчингүй болсон хэрэг зэргийг тухайн хэргийг өмнө шийдвэрлэсэн шүүгчид хуваарилна.

2.5 Шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх болон ИХШХШТХ-ийн 124 дүгээр зүйлд заасан үндэслэлээр гаргасан хүсэлтийг уг шийдвэрийг гаргасан шүүгчид хуваарилна.

2.6. ИХШХШТХ-ийн 117 дугаар зүйлд зааснаар шүүгч хэргийг шүүгчийн захирамжаар, шүүх бүрэлдэхүүн шүүхийн тогтоолоор шийдвэрлэсэн тохиолдолд уг шийдвэрийг эс зөвшөөрч гаргасан гомдлыг тус хуулийн 171.1-д зааснаар шүүх бүрэлдэхүүн хүлээн авсан тохиолдолд уг хэргийг шийдвэрлэсэн шүүгчээр нь эцэслэн шийдвэрлүүлнэ. Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянуулах тухай хүсэлтийг уг хэргийг шийдвэрлэсэн шүүгчийг алгасаад тойрогт оруулж хуваарилуулна.

2.7. Хэргийг нэгтгэх тохиолдолд иргэний хэрэг эхэлж үүсгэсэн захирамжтай хэрэгт нэгтгэж, нэг ажиллагаагаар хэргийг хамтатган шийдвэрлэнэ.

2.8. Хэргийг тусгаарлан шийдвэрлэх тохиолдолд тусгаарлаж буй хэргийг тухайн шүүгчид хуваарилна.

2.9. Эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэй байгуулсан эвлэрлийн гэрээ баталгаажуулах, хэрэг хянан шийдвэрлэсэн шүүгчийн эзгүйд шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх хүсэлт зэргийг системээс “тойрог дотор санамсаргүй” аргаар хуваарилна.

2.10. Давж заалдах болон хяналтын шатны шүүхэд гомдол гаргах хугацаа сэргээлгэх хүсэлтийг хэргийг шийдвэрлэсэн шүүгчид өгнө.

#### Гурав. Бусад

3.1. Шүүгч ээлжийн амралттай, бусад хүндэтгэн үзэх шалтгаантай тохиолдолд хэргийг шүүгчид хэрхэн хуваарилах, дээрх байдлаас шалтгаалж шүүх бүрэлдэхүүний шүүгчийг өөрчлөн томилох зэрэг асуудлыг доорх байдлаар шийдвэрлэнэ.



3.2. Шүүгч нарт ээлжийн амралт эхлэхээс хуанлийн 14 хоногийн өмнө хэрэг хуваарилалт зогсож, ажилд орохоос ажлын 5 хоногийн өмнө хэрэг хуваарилна.

3.3. Шүүгч ээлжийн амралтаа дутуу эдлээд 14 хоногоос дээш хугацаагаар нөхөж амрах тохиолдолд хэрэг хуваарилалтыг амрахын өмнөх өдрөөс эхлэн зогсоож, ажилдаа орох өдөр нь хэргийг хуваарилна.

3.4. Шүүгч, шүүх бүрэлдэхүүн хүндэтгэн үзэх шалтгааны улмаас шүүх хуралдаан товлогдсон, хэргийг эцэслэн шийдвэрлэх боломжгүй тохиолдолд хамгийн сүүлд хэрэг авсан шүүгчийн дараагийн шүүгчид 1.1.д заасан сугалаагаар тогтоосон нэрсийн дарааллаар хэргийг хуваарилна.

3.5. Хэрэг хуваарилагдсан шүүгч зайлшгүй хүндэтгэн үзэх шалтгаанаас бусад тохиолдолд хэргийг өөрөө шийдвэрлэж дуусгана.

3.6. Хуваарилагдсан хэрэг, өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авсан шүүгч, шүүх бүрэлдэхүүнд томилогдсон шүүгчийг гагцхүү хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмаар зөвшөөрөгдсөн татгалзал, үндэслэл үүссэн, эсхүл шүүгч, шүүх бүрэлдэхүүн солигдох бусад нөхцөлд тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс тогтоосон журмын дагуу шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг томилно. Зөвлөгөөний шийдвэрийг үндэслэн хэрэг, өргөдөл, гомдол, хүсэлтийг хуваарилахдаа тухайн шүүгчийг тойргоос гарган бусад шүүгч нарт тойрог дотор санамсаргүй байдлаар системээс хуваарилна.

3.7. Шүүгч эзгүй тохиолдолд Иргэн-2014 нэгдсэн системд байршуулсан нэрсийн дарааллаар бие биенээ тойргийн байдлаар орлон ажиллах ба энэ дарааллыг баримтлах боломжгүй тохиолдолд ганцаараа үлдсэн хэн байгаа шүүгч нь бүгдийг орлон ажиллана.

3.8. Шүүх бүрэлдэхүүнээр хэргийг шийдвэрлэж байгаа тохиолдолд хэргийг илтгэсэн шүүгч нь даргална.

3.9. Ерөнхий шүүгчид хуваарилагдан ирсэн хэрэгт нь гаргасан өргөдөл, гомдол, хүсэлтээс бусад өргөдөл, гомдол, хүсэлтийг шүүгч нарын нэгэн адил хуваарилна.

3.10. Шүүх нүүдэллэн ажиллах үед шүүхийн захиргааны ажилтан шинээр нэхэмжлэл авахдаа ИХШХШТХ-ийн 62 дугаар зүйлд заасны дагуу бүрдүүлбэрийг шалгаж, ирсэн цаг, минутын дарааллаар тэмдэглэгээ хийж, шүүхэд буцаж ирмэгц мэдээлэл лавлагааны мэргэжилтэнд шилжүүлнэ.

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАМЫН-ҮҮД СУМ ДАХЬ  
СУМ ДУНДЫН ШҮҮХИЙН ШҮҮГЧДИЙН ЗӨВЛӨГӨӨН